БАТЛАВ
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД
СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ЦЭВЭЭНРАВДАН
..... оны ..... дугаар сарын .....

MTY0350 9051007 1126010002

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2026 оны 03 дугаар сарын 18

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН ОНОШИЛГООНЫ ТӨВИЙН 4 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАР, ОНОШИЛГООНЫ ТӨВИЙН БАРИЛГЫН ХАЯАВЧИЙГ ТЭГШИЛЖ ЦУТГАХ АЖИЛ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах Өмнөговь аймаг дахь сум дундын оношилгооны төвийн 4 айлын орон сууцны барилгын дээвэр болон гадна хаалга, цонхыг засварлах, мөн оношилгооны төвийн барилгын хаяавчийг тэгшилж цутгах ажил болно.

1. Барилгын дээврийн засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНбД стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх
2. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
3. Талбайн дотоод зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах
4. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадалшгүй ажлын зардал зэргийг тооцож "Барилгын төсөв зохиох дүрэм" БНбД 81-95-20-ыг мөрдлөг болгоно.
5. Үнийн саналд зураг төсвийн үнэ 1,150,000 төгрөгөөр, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-аар тусгаж ирүүлнэ.
6. Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан /зураг/ төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартыг мөрдөх
3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

5. Барилгын засварын ажлын талбайн ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

7. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

9. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/ 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/, гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага чанарын баталгаа гаргаж өгнө.

10. Ажлын тоо хэмжээний жагсаалтыг хавсаргав.

БОЛОВСРУУЛСАН:
СУМ ДУНДЫН ОНОШИЛГООНЫ
ТӨВИЙН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Л.ЦЭНД-АЮУШ

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

4 АЙЛ, ДЭЭВРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гелмөр төмрөөр хийсэн дээвэр буулгах	м2	162
2	Дээврийн сараалжийн зоргодсон хавтанг буулгах	м2	162
3	Дээврийн эрдэс хөвөн дулаалга задлаж буулгах	м2	132
4	Хучилт дээрх хогийг цэвэрлэх	м2	132
5	Хучилттын гадаргууг халдваргүйжүүлэх	м2	132
6	Эрдэс хөвөн хавтангаар модон хучилт дулаалах d-250мм	м2	132
7	Төмөр дээврийн сараалжийг банзаар шинэчилж солих	м2	162
8	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	м2	162
9	Дээврийн гарниз, хормойг хайрцаглахыг цэвэр банзаар хийх	м2	18.84
10	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд экскаваторраар ачих	м3	48

ХААЛГА, ЦОНХНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Цонхыг задлаж буулгах	м2	18.2
2	Вакум цонх хананд суулгах	м2	18.2
3	Цонхны зай завсрыг баллонтой шуршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	15.6
4	Төмөр хаалгыг буулгах	м2	7.56
5	Гадна хананд төмөр хаалга суулгах	ш	4
6	Хаалганы зай завсрыг баллонтой шуршдэг хөөсөөр чигжих	м2	7.56

МЭМТ-ИЙН БАРИЛГЫН ХАЯАВЧ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хаяавчны дор хайрга асгаж тэгшлэх, нягтруулах	м3	4.4
2	Бетон хаяавч цутгах	м3	5.3